



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/Ч/М

Есөнбулаг

Хантайшир уулын аймгийн 100 жилийн
ойг тэмдэглэхэд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны "Зарим аймаг байгуулагдсаны ойг тэмдэглэх болон баяр наадмын хугацааг тогтоох тухай" 221 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн "Аймгийн төсөв батлах тухай" 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хантайшир уулын аймгийн 100 жилийн ойг тэмдэглэх арга хэмжээнд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 50,951,000 (тавин сая есөн зуун тавин нэгэн мянга) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас баяр наадам зохион байгуулах зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 09
дугаар сарын 07-ны өдрийн 114 дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Медаль	100	104,500	10,450,000
2	Медалийн үнэмлэх	110	89,100	9,801,000
3	Сайн дурын ажилтны хантааз	300	15,000	4,500,000
4	Гэрлийн шонгийн хос, туг далбаа	500	30,000	15,000,000
5	88 багийн туг	88	25,000	2,200,000
6	Төрийн далбаа, аймгийн туг	60	-	9,000,000
	Нийт дүн			50,951,000

__оОо__